

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

“Глобалмонголиа Холдингс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11:16 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Соёмбо тауэр, 21 давхар, 211 тоотод эхлэв.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ким Ки Хюун даргалав.
Хурлын ирц: 60.2%

ХУРАЛД ОРОЛЦСОН ГИШҮҮД:

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

- Пак Чан Сүг төлөөлж Хан Гюү Бун
- Жанг Кёнг Сүкийг төлөөлж Хан Гюү Бун

Бусад:

- Э.Гандиймаа
- Б.Ананд
- Т.Отгон
- Г.Хажидмаа
- М.Лхамсүрэн
- Ү.Ананд
- М.Энхмарал

Хурлын тэмдэглэлийг Т.Отгон хөтлөв.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай;
- ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнах;
- Бусад.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ким Ки Хюун: Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит нээж байна. Хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ким Ки Хюун миний бие даргална. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулна уу.

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

*Тооллогын комиссын дарга Г.Хажидмаа ирц, итгэмжлэл болон
Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлахтай холбоотой баримт
бичгүүдийг танилцуулав.*

Г.Хажидмаа: “Глобалмонголиа Холдингс” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар 64,600 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 107,306 ширхэг энгийн хувьцааны 60.2 % болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлж байна.

Компанийн 29,200 ширхэг хувьцааг эзэмшигч Пак Чан Сү (PARK CHAN SOO) (бүртгэлийн дугаар KOR740315M, РД: 740315-1650822), 35,400 ширхэг хувьцааг эзэмшигч Жанг Кёнг Сүк (CHANG KYOUNGSUK) (бүртгэлийн дугаар KOR7302161F, РД: 730216-2650511) нар 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Хан Гюү Бун (бүртгэлийн дугаар KOR6101194M, Гадаад паспортын дугаар M60629108)-д итгэмжлэл олгосон ба энэхүү итгэмжлэл нь БНСУ-д үйлдэгдсэн бөгөөд Апостилиар баталгаажиг, 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Монгол хэл дээр баталгаат орчуулагчаар орчуулагдаж ирсэн байна.

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Глобалмонголиа Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 60.2%-ийг эзэмшигч хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож байна.

Ким Ки Хюун: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн тул өнөөдрийн хурлыг хүчин төгөлдөр гэж дахин мэдэгдэж байна. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар бид дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай;
3. ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнах;
4. Бусад.

Ким Ки Хюун: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх нэгдүгээр асуудал бол Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн М.Лхамсүрэн танилцуулна.

*“Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн үйл
ажиллагааны тайлан, “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2023
оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, “Глобал Монголиа
Холдингс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг
баталгаажуулсан аудитын дүгнэлтийг танилцуулав.*

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн М.Лхамсүрэнгийн танилцуулгыг сонслоо. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудалд санал хураалт явуулья.

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН

ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигч нар Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлахыг дэмжиж байна уу?

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигч нар 100 хувийн саналаар дэмжив.

Ким Ки Хюун: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх нэгдүгээр асуудлыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигч нар 100%-ийн саналаар дэмжиж шийдвэрлэлээ. Одоо хоёрдугаар асуудлыг хэлэлцүүлье. Бидний хэлэлцэх хоёрдугаар асуудал бол ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнах тухай асуудал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн М.Лхамсүрэн танилцуулна.

М.Лхамсүрэн: Компанийн тухай хуулийн 46 дугаар 46.8 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт тус тус зааснаар *Ногдол ашигийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах* бөгөөд дараах тохиолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
3. компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

Компанийн тухай хуулийн дээрх зохицуулалтын дагуу ногдол ашигийг зөвхөн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилахаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, компани ашигтай ажиллаагүй нөхцөлд хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилахгүй.

Глобал Монголиа Холдингс ХК нь 2023 онд 7,421,050.00 (долоон сая дөрвөн зуун хорин нэгэн мянга тавь) төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна. Иймд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл “компани нь 2023 онд ашигтай ажиллаагүй тул хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилахгүй” гэж шийдвэрлэсэн.

Ким Ки Хюун: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн М.Лхамсүрэн ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлийг тайлагналаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх хоёрдугаар асуудалд санал хураахгүй. Учир нь энэхүү асуудал шийдвэрлэх бус танилцуулах асуудал болно. Яагаад ногдол ашиг хуваарилаагүй талаар дэлгэрэнгүй танилцах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нар хурлын материалтай танилцаж болно.

Одоо гуравдугаар асуудлыг хэлэлцүүлье. Бидний хэлэлцэх гуравдугаар асуудал бол Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай асуудал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн М.Лхамсүрэн танилцуулна.

М.Лхамсүрэн: Стратегийн хөрөнгө оруулагчаас компанид хөрөнгө оруулалт оруулахаар төлөвлөж байсан. Төлөвлөгөөний дагуу анхны хөрөнгө оруулалтаар 1,000,000 ширхэг хувьцааг нэмж гаргах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан. Одоо хөрөнгө оруулалтын мөнгө нь хүлээгдэж байна. Тухайн үед хуваарийн дагуу хоёр дахь хөрөнгө оруулалт нь өнөөдрийн хурлаар шийдвэрлэгдэх байсан. Гэвч өмнөх хөрөнгө оруулалт

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН

ТЭМДЭГЛЭЛ

хийгдээгүй байгаа тул энэхүү асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулах саналтай байна.

Ким Ки Хюун: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигч нарт мэдээлэл хүргэлээ. Энэ нь мөн санал хурааж батлах асуудал биш тул хойшлуулаад танилцуулга дууслаа гэж үзлээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан “Бусад” гэсэн асуудалд хэлэлцэх асуудал орж ирээгүй тул хэлэлцүүлэхгүй байхаар шийдвэрлэж байна

Хан Гюү Бун: Надад нэг асуулт байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлуудын зөвхөн эхний асуудал нь батлах, бусад нь танилцуулах асуудал байсан уу? Анх хөрөнгө оруулалт татахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоол гаргаж Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан. Дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг өмнө нь шийдвэрлэсэн ч одоог хүртэл дүрмийн сан нэмэгдээгүй байна. Өнөөдрийн хурлаар мөн дүрмийн сан нэмэх асуудал хойшилж байна. Энэ асуудал яагаад хойшлоод байна вэ?

М.Лхамсүрэн: Энэ нь хоёр өөр хөрөнгө оруулалтын асуудал юм. Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор дүрмийн санг нэмсэн нь одоо нэмж хувьцаа гаргах асуудалтай холбоогүй. Өмнөх хөрөнгө оруулалт орж ирээгүй байгаа тул энэ асуудлыг хойшлуулж байна.

Хан Гюү Бун: хоёрдугаар хөрөнгө оруулалттай холбоотой асуудал гэж ойлгох уу?

Ким Ки Хюун: тийм, Хан Гюү Бун нь 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дотор хөрөнгө оруулалт орж ирэх нь тодорхой юу? Яг хэзээ хөрөнгө оруулалт орж ирэх вэ? Гэсэн асуудлыг тодруулсан. Эхний хөрөнгө оруулалт нь 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар орж ирэхээр тойм гарсан.

Хан Гюү Бун: Дахин нэг цэгцэлж асууя. Хоёрдугаар хөрөнгө оруулалтын асуудал нь нэгдүгээр хөрөнгө оруулалт хойшилж байгаагаас хамааран хойшилж байгаа юу? Хоёрдугаар хөрөнгө оруулалт нээлттэй юу? Хойшлуулж байгааг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх шаардлагатай юу?

М.Лхамсүрэн: Хоёрдугаар хөрөнгө оруулалт нь хаалттай хөрөнгө оруулалт байх болно. Мөн энэхүү асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх шаардлагатай. Шийдвэрлэх асуудал бүрээр шийдвэр гаргах шаардлагатай.

Хан Гюү Бун: Яагаад эхний хөрөнгө оруулалт хойшилж байна вэ?

Ким Ки Хюун: Яагаад хөрөнгө оруулалтыг анх хоёр хуваахаар болов?

М.Лхамсүрэн: Нэгдүгээрт, анх бүтэн дүнгээр хөрөнгө оруулалт орж ирэхэд хувьцааны үнэ дээр шаардлага тавигдсан. Иймд нэгж хувьцааны зах зээлийн үнэ өндрөөр тогтоогдсон бөгөөд тухайн үед хувьцааны ханш огцом өсөлттэй байсан. Иймд эхний ээлжид компанийн хувьцаа эзэмшигч болсны дараа дахин хөрөнгө оруулалт хийх нь зөв гэж үзсэн тул хөрөнгө оруулалтыг хоёр хуваахаар болно Хоёрдугаарт, коснайн компанийн хөрөнгө оруулалт хийх шийдвэрээс шалтгаалан компанид орж ирэх хөрөнгө оруулалт хойшилсон.

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

Хан Гюү Бун: Нэгдүгээр хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй бол яах вэ? Санхүүгийн зохицуулах хорооноос авсан бүх зөвшөөрөл маань хүчингүй болж байгаа гэсэн үг үү?

Б.Ананд: Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр хугацаагүй гардаг. Гэвч хугацаа зааж мэдэгдэл ирэхийг үгүйсгэхгүй. Гэсэн ч хөрөнгө оруулалт 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дотор орж ирэхгүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл хүчингүй болохгүй.

Ким Ки Хюун: Хувьцаа эзэмшигч нарт өөр асуулт байна уу?

Хан Гюү Бун: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор нэмэлт санал байхгүй. Хойшлуулахад татгалзах зүйлгүй. Хоёрдугаар асуудлаас түдгэлзэж байна.

Ким Ки Хюун: үүгээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигч нарт саналын хуудсыг тарааж өгөв.

Тооллогын комисс саналын хуудсыг тоолж, хүлээн авав.

Тооллогын комисс санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулав..

Г.Хажидмаа: “Глобалмонголиа Холдингс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй. Үүнд:

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1.1. **Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай** асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 64,600 ширхэг хувьцаа буюу 100% зөвшөөрсөн, 0 ширхэг хувьцаа буюу 0% татгалзсан, 0 ширхэг хувьцаа буюу 0% түдгэлзсэн.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
64,600	100%	0	0%	0	0%

1.2. **Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай** асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0 ширхэг хувьцаа буюу 0% зөвшөөрсөн, 0 ширхэг хувьцаа буюу 0% татгалзсан, 64,600 ширхэг хувьцаа буюу 100% түдгэлзсэн.

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
0	0%	0	0%	64,600	100%

Хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12:07 цагт дуусав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дараах асуудлыг шийдвэрлэж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол гаргав.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухайд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт№1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт№2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Бэк Квангюэл /- д үүрэг болгосугай.

Дараах асуудлыг танилцуулж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргын тогтоол гаргав.

Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухайд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан Компани нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулсугай.

ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнасан тухайд:

- Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ тайлагнасныг хангалттай гэж үзсүгэй.

Бусад асуудал хэлэлцсэн эсэх тухайд:


- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан “Бусад” гэсэн асуудалд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс ямар нэг асуудал хэлэлцүүлэхээр санал гаргаагүй тул “Бусад” гэсэн асуудлыг хэлэлцээгүй болохыг дурьдсугай.

**“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

ХУРЛЫН ДАРГА:

/КИМ КИ ХЮУН /

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



/Т.ОТГОН /